

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ КЛИРИНГИЙН ТӨВИЙН СИСТЕМИЙН ДҮРЭМ

Агуулга

Нэг. Нийтлэг үндэслэл	2
Хоёр. Төлбөрийн картын төлбөр тооцоог зохион байгуулах.....	2
Гурав. Үр дүнгийн төлбөр тооцоо хийх, үр дүнгийн төлбөр тооцоо хийх барьцаа.....	5
Дөрөв. Клирингийн төвийн үйлчилгээний шимтгэл.....	6
Тав. Маргаантай гүйлгээ шийдвэрлэх зарчим	6
Зургаа. Хураагдсан карт	9
Долоо. Техникийн шаардлага	10
Найм. Шинээр Гишүүн бүртгэх, хүчингүй болгох	12
Ес. Эрсдэлийн удирдлага	14
Арав. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах	14
Арван нэг. Хавсралтууд.	
Хасвралт 1: Төлбөрийн картын төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээний загвар	17
Хасвралт 2: Нэр томъёоны тодорхойлолт	22
Хасвралт 3: Гүйлгээ боловсруулах, үр дүнгийн тооцоолол хийх зарчим, хуваарь	24
Хасвралт 4: Маргаан шийдвэрлэх хариу өгөх.....	35
Хасвралт 5: Тасралтгүй үйл ажиллагааны маягт.....	41
Хасвралт 6: Бин дугаар бүртгэх маягт.....	42
Хасвралт 7: Клирингийн төвийн үйл ажиллагааны тайлан.....	43
Хасвралт 8: Клирингийн төвийн бүрэн эрхт төлөөлөгчид.....	44


Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Худалдаа хөгжлийн банкны Клирингийн төвийн системийн дүрэм”-ийн зорилго нь Клирингийн төвийн сүлжээнд Гишүүн банкуудын хоорондын төлбөрийн картын төлбөр тооцоог зохион байгуулах, Клирингийн төв (цаашид “Клирингийн төв” гэх), Гишүүн банк (цаашид “Гишүүн банк”, хамтад нь “Оролцогч талууд” гэх) хоорондын эрх, үүрэг, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангуулахад оршино.
- 1.2. Клирингийн төв нь гишүүн банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг дамжуулах, төлбөр тооцоог зохион байгуулахад Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Монголбанкнаас баталсан “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам” болон “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.
- 1.3. Энэхүү дүрмийг ХХБ-ны Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, Монголбанкаар хянуулна.
- 1.4. Гишүүн банктай байгуулах “Төлбөрийн картын төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээ”-г энэхүү дүрмийн дагуу боловсруулж, Гишүүн банктай байгуулна.
- 1.5. Дүрэм болон түүний хавсралтуудад хэрэглэсэн нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкны “Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д болон энэхүү дүрмийн Хавсралт 2-д заасны дагуу ойлгоно.


Хоёр. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ТӨЛБӨР ТООЦООГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 2.1. ХХБ-ны Клирингийн төв нь Гишүүн банк хоорондын картын гүйлгээг дамжуулах, үр дүнгийн тооцоолол хийх үйл ажиллагааг эрхлэх бөгөөд Хавсралт 1-д заасан загварын дагуу Гишүүн банктай “Төлбөрийн картын төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээ” байгуулж ажиллана.
- 2.2. Клирингийн төв нь дотоодын гүйлгээг дараах байдлаар дамжуулна.
 - 2.2.1. Хэрэглэгчийн цахим мэдээ үүсгэгчид төлбөрийн картаар дамжуулан үүсгэсэн шилжүүлгийн цахим мэдээг карт хүлээн авагч нь ХХБ-ны клирингийн төвд илгээнэ.
 - 2.2.2. ХХБ-ны клирингийн төв нь цахим мэдээг карт гаргагчид дараах байдлаар дамжуулна:
 - 2.2.2.1. Гишүүн банк хоорондын гүйлгээний хувьд карт гаргагчид (Схем 1)
 - 2.2.2.2. Гишүүн банк ҮЦГТ хоорондын гүйлгээний хувьд ҮЦГТ-өөр дамжуулан карт гаргагчид (Схем 2)
 - 2.2.2.3. Гишүүн банк VISA хоорондын гүйлгээний хувьд VISA International олон улсын төлбөрийн системээр дамжуулан карт гаргагчид (Схем 3)
 - 2.2.2.4. Гишүүн банк Mastercard хоорондын гүйлгээний хувьд Mastercard worldwide олон улсын төлбөрийн системээр дамжуулан карт гаргагчид (Схем 4)
 - 2.2.2.5. Гишүүн банк UPI хоорондын гүйлгээний хувьд ҮЦГТ-өөр дамжуулан карт гаргагчид (Схем 5)
 - 2.2.2.6. Гишүүн банк JCB хоорондын гүйлгээний хувьд JCB олон улсын төлбөрийн системээр дамжуулан карт гаргагчид (Схем 6)
 - 2.2.3. Карт гаргагч нь тухайн цахим мэдээг шалгаж баталгаажуулан ХХБ-ны клирингийн төвд илгээнэ.
 - 2.2.4. ХХБ-ны клирингийн төв нь тухайн цахим мэдээг карт хүлээн авагчид дамжуулна.
 - 2.2.5. Карт хүлээн авагч тухайн цахим мэдээг эцэслэнэ.

Схем 1. Гишүүн банк хоорондын гүйлгээг дараах байдлаар дамжуулна.




Схем 2. Гишүүн банк болон ҮЦГТ-ийн гүйлгээг дараах байдлаар дамжуулна.




- 2.2.6. Гишүүн банкны илгээсэн цахим мэдээний хариуг 25 секунд хүлээнэ. ХХБ нь дамжуулсан цахим мэдээний хариуг 20 секунд хүлээнэ.
- 2.2.7. Үндсэн гүйлгээг Монголбанкны баталсан “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-д зааснаар ойлгоно. Гишүүн банк нь Монголбанкны баталсан холбогдох журам, дүрмийн дагуу үндсэн гүйлгээг өөрийн системд карт гаргагч нь заавал, карт хүлээн авагч нь өөрийн терминал, үйл ажиллагааны чиглэлээс хамааран сонголтоор нэвтрүүлнэ.
- 2.2.8. Гишүүн банк нь нэмэлт гүйлгээг Монголбанкны баталсан “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-д зааснаар ойлгоно. Гишүүн банк нь Монголбанкны баталсан холбогдох журам, дүрмийн дагуу нэмэлт гүйлгээг өөрийн системд нэвтрүүлж, хүлээн авна.
- 2.2.9. Гишүүн банк нь нэмэлт гүйлгээг өөрийн системд нэвтрүүлээгүй тохиолдолд (ҮЦГТ, ХХБ эсхүл Гишүүн банкнаас) “Системд дэмжигдэхгүй” гэсэн цахим мэдээний хариу өгнө.
- 2.3. Клирингийн төв нь Олон улсын төлбөрийн системд хийгдэх картын үйл ажиллагааг олон улсын төлбөрийн картын хамтран ажиллах гэрээний дагуу өөрийн Клирингийн төвөөр дамжуулан гүйцэтгэж болно.
 - 2.3.1. Олон улсын банк болон Гишүүн банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг дараах байдлаар дамжуулна.


Схем 3. Олон улсын VISA International байгууллагын төлбөрийн картыг гүйлгээг дараах байдлаар дамжуулна.




Схем 4. Олон улсын Mastercard worldwide байгууллагын төлбөрийн картыг гүйлгээг дараах байдлаар дамжуулна.



Схем 5. Олон улсын UnionPay International байгууллагын төлбөрийн картыг гүйлгээг дараах байдлаар дамжуулна.



Схем 6. Олон улсын JCB International байгууллагын төлбөрийн картыг гүйлгээг дараах байдлаар дамжуулна.



- 2.4 Олон улсын төлбөрийн системд хийгдэх гүйлгээ нь тухайн төлбөрийн системийн дүрэм, журмын дагуу зохицуулагдана.

Гурав. ҮР ДҮНГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ, ҮР ДҮНГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ БАРЬЦАА

- 3.1. Клирингийн төв нь Гишүүн банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг өөрийн системээр дамжуулан гүйцэтгэнэ.
- 3.2. Клирингийн төв нь Гишүүн банкны ҮЦГТ-өөр дамжсан хоорондын төлбөрийн картын гүйлгээний үр дүнгийн тооцооллыг харилцан суутгах зарчмаар хийнэ.
- 3.3. Клирингийн төв нь үр дүнгийн тооцооллыг хийж, Хавсралт 3 “Гүйлгээ боловсруулах, үр дүнгийн тооцоолол хийх зарчим, хуваарь”-т заасны дагуу Монголбанкны “Банксүлжээ” системд дамжуулна.
- 3.4. Клирингийн төв нь Олон улсын төлбөрийн системээр хийгдсэн гүйлгээг тухайн системийн үр дүнгийн тооцооллын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 3.5. Гишүүн банк нь Монголбанк дахь өөрийн дансанд үр дүнгийн тооцоо хийх зорилгоор барьцаа мөнгөн хөрөнгийг нөөц болгон байршуулна.
- 3.6. Гишүүн банк хоорондын төлбөр тооцоо гүйцэтгэх зорилгоор оролцогчийн Банксүлжээ дэх төлбөр тооцооны дансанд тусгаарласан эх үүсвэрийн нөөцийн хэмжээ, түүний өөрчлөлтийн талаар Картын гүйлгээний клирингийн болон Банксүлжээ систем хооронд солилцох цахим мэдээг нөөц баталгаажуулах мэдээ гэнэ.
- 3.7. Гишүүн банк тус бүр нөөц баталгаажуулах мэдээг өдөрт 5 удаа дараах цагуудад солилцоно: 10:00, 11:30, 14:30, 15:30, 16:50.
- 3.8. Гишүүн банк тус бүр нөөцийн хэмжээг Банксүлжээ системээр дамжуулан удирдана.
- 3.9. ХХБ нь тухайн өдрийн төлбөрийн картан банк хоорондын гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоог Банксүлжээ системээр гүйцэтгэнэ.
- 3.10. Гишүүн банк нь нөөцийн удирдлага гүйцэтгэхэд дараах үүрэгтэй. Үүнд:
 - 3.10.1. Нөөцийг зөв зохистой удирдах;
 - 3.10.2. Үр дүнгийн төлбөр тооцоо хийх, мөн шимтгэлийн дүнг тооцож нөөцийн хязгаарыг тодорхойлох;
 - 3.10.3. Нөөц болгон царцаасан мөнгөн хөрөнгөнөөс зөвхөн тухайн оролцогчийн гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоог хийх;
 - 3.10.4. Өөрийн нөөцийн тухай мэдээллийг Банксүлжээ, картан системээс авах;
 - 3.10.5. Банксүлжээ системд клирингийн системээр дамжих гүйлгээний нөөцөө ажлын өдөр эхлэхэд хангалттай мөнгөн дүнгээр эсхүл тухай бүр нэмэгдүүлэх;
- 3.11. Гишүүн банк нь нөөцийг удирдахад дараах үйлдлийг хийхийг хориглоно.
 - 3.11.1. Тухайн өдрийн гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоо хийх хүртэл нөөцийг чөлөөлөх;
 - 3.11.2. Бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх.

Дөрөв. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

4.1. Худалдаа, хөгжлийн банкны шимтгэл

- 4.1.1. ХХБ нь амжилттай дамжуулсан төлбөрийн картын гүйлгээний шимтгэлийг “Худалдаа, хөгжлийн банкны Клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөл”-д заасны дагуу суутгаж авна.
- 4.1.2. “Худалдаа, хөгжлийн банкны Клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөл”-ийг ХХБ-ны гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 4.1.3. ХХБ нь буцаалтын болон амжилтгүй гүйлгээнээс шимтгэл авахгүй.
- 4.1.4. Буцаалтын гүйлгээний шимтгэлийг буцааж буй гүйлгээний дүнгээс тооцож, залруулга хийнэ.

4.2. Шимтгэл хуваарилах зарчим

- 4.2.1. Дотоодын гүйлгээ дамжуулсан карт хүлээн авагч банк болон карт гаргагч банканд ногдох шимтгэлийг Монголбанкнаас баталсан “Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл” болон бусад холбогдох дүрэм журамд заасны дагуу хуваарилах бөгөөд олон улсын гүйлгээ дамжуулсан карт хүлээн авагч банк болон карт гаргагч банканд ногдох шимтгэлийг “Худалдаа, хөгжлийн банкны Клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөл”-д заасны дагуу хуваарилна.

Тав. МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧИМ

5.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 5.1.1. Картын маргаантай гүйлгээ нь дараах Оролцогч талуудын хооронд үүснэ. Үүнд:
 - 5.1.1.а. Гишүүн банк хооронд;
 - 5.1.1.б. Гишүүн банк болон Дотоодын банк хооронд;
 - 5.1.1.в. Гишүүн банк болон Олон улсын банк хооронд;
- 5.1.2. Энэхүү дүрмийн 5.1.1 дэх заалтад заасан Оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг энэхүү дүрэм болон “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн хүрээнд шийдвэрлэнэ.
- 5.1.3. Гишүүн банк хооронд, Гишүүн банк дотоодын банк хооронд болон Гишүүн банк олон улсын банк хооронд үүссэн аливаа маргаантай холбоотой хүсэлт илгээх, хүлээн авах, маргаан илгээх, хүлээн авахдаа Клирингийн төвийн www.cardcentre.mn цахим хуудсыг ашиглана.
- 5.1.4. Маргаанд Оролцогч талууд дараах төрөл, шалтгаанаар маргаан үүсгэнэ.

№	Маргаан гарах тохиолдлууд	Төхөөрөмж		
		АТМ	ПОС	ПОБ
1	Илүү эсхүл дутуу дүнгээр олгосон	+		+
2	Луйвар (хуурамч болон алдагдсан картаар хийгдсэн гүйлгээ)	+	+	+
3	Илүү эсхүл дутуу дүнгээр хийгдсэн		+	
4	Гүйлгээгээ санахгүй байгаа	+	+	+
5	Бэлнээр эсхүл өөр картаар хийгдсэн		+	
6	Баримт хэвлэгдээгүй		+	+
7	Гүйлгээ автоматаар буцаагдсан	+	+	+

8	Бэлэн мөнгө гараагүй	+		
9	Гүйлгээ санамсаргүй буцаагдсан		+	+
10	КЭ-ээс дутуу дүнгээр хасалт хийгдсэн		+	+
11	Давхар хийгдсэн гүйлгээ		+	
12	Цахим банкаар хийгдсэн луйврын гүйлгээ			
13	Цахим банкаар хийгдсэн бусад алдаатай гүйлгээ			
14	Бусад	+	+	+

5.1.5. Маргаанд Оролцогч талууд 5.1.4-т заасан шалтгаануудаар маргаан үүсгэхдээ дараах нотлох баримтуудыг хавсаргасан байна.

№	Маргаан гарах тохиолдлууд	Төхөөрөмж		
		АТМ	ПОС	ПОБ
1	Гүйлгээ санамсаргүй буцаагдсан		Гүйлгээний гарын үсэгтэй баримт, КҮБ-аас ирүүлсэн хүсэлт	
2	КЭ-ээс дутуу дүнгээр хасалт хийгдсэн		КҮБ эсхүл карт хүлээн авагч банкнаас ирүүлсэн хүсэлт	
3	Илүү мөнгө олгох	Мөнгөн дэвсгэртээ нүдлэх		Мөнгөн дэвсгэртээ нүдлэх

5.2 МАРГААН ҮҮСГЭХ, ШИЙДВЭРЛЭХ

- 5.2.1 Гишүүн банк нь 5.1.4-д заасан шалтгаанаар хүсэлт, маргаан үүсгэж болох ба зөвхөн амжилттай гүйлгээнд маргаан үүсгэнэ.
- 5.2.2 Гишүүн банк хооронд гүйлгээний мэдээлэл, нотлох баримт хүсэх, маргаан үүсгэх хугацаа нь АТМ, ПОБ дээр тухайн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 30 хоног, ПОС төхөөрөмж, цахим худалдан авалт дээр гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 60 хоног байх бөгөөд уг хугацааны дотор [Www.cardcentre.mn](http://www.cardcentre.mn) цахим хуудсаар дамжуулан ХХБ-ны холбогдох ажилтанд хүсэлт илгээнэ.
- 5.2.3 Гишүүн банк нь маргаан үүсгэхдээ 5.1.5-д заасан нотлох баримтын хамт [Www.cardcentre.mn](http://www.cardcentre.mn) цахим хуудсаар хүсэлт илгээнэ.
- ХХБ-руу үүсгэсэн хүсэлт, маргаан бол ХХБ-ны холбогдох ажилтан хүлээн авч хүсэлтийг шалгаж эхэлснээр маргаан үүснэ.
 - Бусад Гишүүн банк руу үүсгэсэн хүсэлт, маргаан бол ХХБ-ны холбогдох ажилтан дараагийн ажлын өдөрт багтан бусад Гишүүн банканд [Www.cardcentre.mn](http://www.cardcentre.mn) цахим хуудсаар хүсэлт илгээн маргаан үүснэ.
 - Дотоодын банк руу үүсгэсэн хүсэлт маргаан бол ХХБ-ны холбогдох ажилтан дараагийн ажлын өдөрт багтан ҮЦГТ-ийн оролцогч банкууд руу цахим шуудангаар маргаантай гүйлгээний хүсэлт илгээнэ.
- 5.2.4 5.2.2-т заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд Гишүүн банк ба ХХБ болон бусад Гишүүн банкууд харилцан тохиролцох замаар хүсэлт, маргааныг шийдвэрлэж болно.

- 5.2.5 Гишүүн банк хооронд үүссэн хүсэлт, маргааныг хүлээн авагч тал нь АТМ, ПОБ дээр хийгдсэн гүйлгээ бол ажлын 3 хоног, ПОС, цахим худалдан авалтын гүйлгээ бол ажлын 10 хоногт хүсэлт гаргагч банканд ХХБ-ны www.cardcentre.mn цахим хуудсаар хүсэлтийн хариуг илгээнэ.
- 5.2.6 Гишүүн банк болон дотоодын банк хооронд үүссэн маргаантай гүйлгээг Гишүүн банк ХХБ-ны www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан илгээх ба ХХБ-ны холбогдох ажилтан ҮЦГТ-ийн цахим хуудсаар болон и-мэйлээр дамжуулан шийдвэрлэнэ.
- 5.2.7 Гишүүн банк болон дотоодын банк хооронд үүссэн маргаан үүсгэх хугацаа, тохиолдол, үйл явц нь “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн дагуу хийгдэнэ.
- 5.2.8 Гишүүн банк болон Дотоодын банк хооронд гүйлгээний мэдээлэл, нотлох баримт хүсэх, маргаан үүсгэх хугацаа нь АТМ, ПОС, ПОБ, цахим худалдан авалт дээр эх гүйлгээ хийгдсэн өдрөөс ажлын 30 хоногийн дотор www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан ХХБ-ны холбогдох ажилтанд хүсэлт илгээнэ.
- 5.2.9 “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн Маргаан шийдвэрлэх зарчмын дагуу ПОС-ын давхар хийгдсэн гүйлгээн дээр суутгалын гүйлгээг (chargeback) хийнэ.
- 5.2.10 5.2.8-д заасан хугацаа хэтэрсэн эсвэл маргаан шийдвэрлэгдсэн хариуг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Гишүүн банк болон Дотоодын банкууд эх гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор ҮЦГТ-д хандаж шийдвэрлүүлж болно. Эх гүйлгээ нь ҮЦГТ-ийн системд амжилттай хийгдсэн гүйлгээ байна.
- 5.2.11 ҮЦГТ нь маргааны хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх ба маргаан шийдвэрлүүлсний төлбөрийг “Монголбанк-ны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу Гишүүн банк хариуцна.
- 5.2.12 Дотоодын банкнаас Гишүүн банк руу маргаан үүсгэсэн хүсэлт ирвэл ХХБ-ны холбогдох ажилтан дараагийн ажлын өдөрт багтан www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан Гишүүн банкны холбогдох ажилтанд хүсэлт илгээнэ.
- 5.2.13 Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь гүйлгээний мэдээллийг АТМ, ПОБ дээр хийгдсэн гүйлгээ бол ажлын 2 хоног, ПОС, цахим худалдан авалтын гүйлгээ бол ажлын 8 хоногт, ПОС-ын давхар хийгдсэн суутгалын гүйлгээг ажлын 4 хоногт 5.1.5-д заасан бүхий л нотлох баримтын хамт хүсэлт гаргагч банканд www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан илгээнэ.
- 5.2.14 Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь тухайн хүсэлтийг дараах байдлаар шийдвэрлэнэ.
- а. Хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд www.cardcentre.mn цахим хуудсаар залруулгын гүйлгээ хийх зөвшөөрөл өгснөөр уг хүсэлт, маргаан дуусгавар болно.
 - б. Хүсэлтийг зөвшөөрөөгүй тохиолдолд болон нөгөө талын үүсгэсэн суутгалын гүйлгээг эс хүлээн зөвшөөрвөл хариу гүйлгээ буюу суутгалын буцаалтын гүйлгээг ажлын 4 хоногт багтан www.cardcentre.mn цахим хуудсаар холбогдох тайлбарыг 5.1.5-д заасан нотлох баримтын хамт оруулснаар хүсэлт, маргаан дуусгавар болно.
- 5.2.15 Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь 5.2.13-д заасан хугацаанд огт хариу ирүүлээгүй тохиолдолд “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн дагуу ҮЦГТ автоматаар залруулгын гүйлгээ хийснээр хүсэлт, маргаан дуусгавар болно.
- 5.2.16 Хүсэлт хүлээн авагч Дотоодын банк нь “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн дагуу хүсэлт үүсгэж, шийдвэрлэнэ.
- 5.2.17 Гишүүн банкны карт гадаадын банкны мерчант хооронд үүссэн маргаантай гүйлгээг Гишүүн банк ХХБ-ны оролцоогүйгээр бие даан шийдвэрлэнэ.
- 5.2.18 Гишүүн банк гадаадын банк хооронд маргаан үүсгэх хугацаа, тохиолдол, үйл явц нь VISA International, Mastercard worldwide, UnionPay International, JCB International байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журмын дагуу хийгдэнэ.
- 5.2.19 Гишүүн банкны төлбөрт хүлээн авсан гадаадын банкны картын гүйлгээтэй холбоотой маргаан үүсгэсэн хүсэлт ирвэл холбогдох ажилтан дараагийн ажлын өдөрт багтан www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан Гишүүн банкны холбогдох ажилтанд хүсэлт бүртгэн илгээнэ. Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь гүйлгээний мэдээллийг АТМ, ПОБ дээр хийгдсэн гүйлгээ бол ажлын 5 хоног, ПОС, цахим худалдан авалтын гүйлгээ бол ажлын 10 хоногт багтаан VISA International,

Mastercard worldwide, UnionPay International, JCB International байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журамд заасан бүхий л нотлох баримтын хамт хүсэлт гаргагч банканд ХХБ-ны Www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан илгээнэ.

- 5.2.20 Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь тухайн хүсэлтийг дараах байдлаар шийдвэрлэнэ.
- Хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд ХХБ-ны Www.cardcentre.mn цахим хуудсаар залруулгын гүйлгээ хийх зөвшөөрөл өгснөөр уг хүсэлт, маргаан дуусгавар болно.
 - Хүсэлтийг зөвшөөрөөгүй тохиолдолд ХХБ-ны Www.cardcentre.mn цахим хуудсаар холбогдох тайлбарыг VISA International, Mastercard worldwide, UnionPay International, JCB International байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэж журамд заасан шаардлагатай нотлох баримтын хамт оруулснаар хүсэлт, маргаан дуусгавар болно.
 - Хүсэлт хүлээн авагч Гишүүн банк нь 5.2.19-д заасан хугацаанд огт хариу ирүүлээгүй тохиолдолд VISA International, Mastercard worldwide, UnionPay International, JCB International байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журмын дагуу автоматаар залруулгын гүйлгээ хийснээр хүсэлт, маргаан дуусгавар болно.

5.3 МАЯГТ, НОТЛОХ БАРИМТ, ТҮҮНИЙ БАРИМТЖУУЛАЛТ БА ХАДГАЛАЛТ

- 5.3.1 Маргаантай холбоотой гүйлгээний баримт, холбогдох маягтыг гомдол, маргаан дуусгавар болсон өдрөөс хойш АТМ, ПОС, ПОБ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний лог, зураг, дүрслэл зэрэг цахим мэдээллийг ажлын 30 хоног, гүйлгээний баримт, карт эзэмшигчийн өргөдөл зэрэг цаасан нотлох баримтыг ажлын 65 хоног хадгална.
- 5.3.2 Нотлох баримт бүрдүүлэх, хадгалах, баримтжуулахтай холбоотойгоор гүйлгээний баримтад карт эзэмшигч эсхүл харилцагчийн гарын үсэг (пин кодоор баталгаажсан гүйлгээний баримтад гарын үсэг шаардахгүй), картын дугаар, зөвшөөрлийн код, гүйлгээ хийсэн огноо, КҮБ-ийн оноосон нэр тод, гаргацтай байх ёстой. Хэрэв энэхүү шаардлагыг хангаагүй тохиолдолд нотлох баримтыг хүчингүйд тооцох эрхтэй.
- 5.4 Картын гүйлгээний маргаантай асуудалд Оролцогч талууд гүйлгээний маягтуудыг зөвхөн энэхүү дүрмийн Х

Зургаа. ХУРААГДСАН КАРТ

6.1 Гишүүн банк болон Оролцогч талуудын Улаанбаатар хотод байрлаж буй АТМ төхөөрөмжид хураагдсан төлбөрийн картыг “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн Хавсралт 7 “Хураагдсан карт бүртгэх маягт”-ын дагуу ҮЦГТ-д хүлээлгэн өгч, карт гаргагч банканд түгээнэ.

6.2 ХУРААГДСАН КАРТ ТҮГЭЭХ

- 6.2.1 Карт хүлээн авагч банк нь хураагдсан картын мэдээллийг АТМ төхөөрөмжөөс хураан авснаас хойш ажлын 5 өдрийн дотор (баярын болон нийтээр амрах өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөрт шилжинэ) ҮЦГТ-ийн цахим хуудсанд бүртгүүлнэ.
- 6.2.2 Карт хүлээн авагч банк нь хураагдсан картыг долоо хоногийн 1,3,5 дахь өдөр (баярын болон нийтээр амрах өдөр таарсан тохиолдолд дараагийн сондгой гарагт шилжинэ)-ийн 11:00 цагаас 12:00 цагийн хооронд “Хураагдсан карт бүртгэх маягт”-ын дагуу карт гаргагч банк тус бүрээр битүүмжлэн ҮЦГТ-ийн ээлжийн операторт хүлээлгэн өгнө.
- 6.2.3 Карт гаргагч банк нь 6.2.2 дугаарт заасан өдөр, хугацаанд ҮЦГТ-ийн ээлжийн оператороос карт хүлээн авагч банкны битүүмжлэн ирүүлсэн хураагдсан картыг битүүмжтэй эсэхийг шалгаж хүлээн авна.
- 6.2.4 Карт гаргагч банк нь ҮЦГТ-ийн цахим хуудсанд карт хүлээн авагч банкнаас ирүүлсэн хураагдсан картыг хүлээн авсан тухай баталгаажуулах бүртгэлийг картын дугаараар тулгаж, дараагийн ажлын 1 өдрийн дотор бүртгэнэ.

6.3 КАРТ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ, ХҮЛЭЭН АВАХ ЭРХ

- 6.3.1 Оролцогч нь хураагдсан карт хүлээлгэн өгөх, хүлээн авах эрх бүхий ажилтныг томилж, ҮЦГТ-ийн цахим хуудсанд бүртгүүлж, мэдэгдэнэ.
- 6.3.2 Эрх бүхий ажилтан өөрчлөгдөх (ажилтан шинээр томилогдсон, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй байх гэх мэт) тохиолдолд түүнийг орлон ажиллах ажилтны мэдээллийг ҮЦГТ-ийн цахим хуудсанд тухай бүр бүртгүүлж, мэдэгдэнэ.
- 6.3.3 Гишүүн банкны орон нутагт байрлаж буй АТМ төхөөрөмжид хураагд

- 7.2.1 Гишүүн банк нь төлбөрийн картын сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаа, тавигдсан нөхцөл, шаардлагыг хангаж, түүнтэй холбогдон гарсан системийн саатлыг шийдвэрлэж ажиллана.
- 7.2.2 Гишүүн банк нь ҮЦГТ болон Оролцогч талуудын системд нөлөөлж болохуйц өөрчлөлтийг хийхдээ туршилтын орчинд гүйцэтгэн баталгаажуулсан байна.
- 7.2.3 Гишүүн банкны үндсэн болон нөөц төв нь Монголбанкны баталсан “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ын шаардлагыг хангасан байна.
- 7.2.4 Гишүүн банкны төлбөрийн картын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах үүднээс мэдээлэл солилцох зорилгоор мэдээлэл технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан болон тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэргийг ХХБ-нд жил бүрийн 1-р сард багтаан албан тоотоор хүргүүлж, өөрчлөлт орох бүрд албан тоотоор мэдэгдэнэ.
- 7.2.5 Төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатлын талаарх мэдээллийг Хавсралт 5-д заасны дагуу бусад Оролцогч талуудад болон ҮЦГТ-д мэдэгдэнэ.
- 7.3 Төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатал
- 7.3.1 Гишүүн банк нь өөрийн процессингийн сүлжээ болон картын гүйлгээнд онлайн системийн тасралтгүй горимыг хангаж ажиллана.
- 7.3.2 Гишүүн банк нь урьдчилан төлөвлөсөн засвар, үйлчилгээ хийх зорилгоор картын сүлжээний үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг төлөвлөгөөт зогсолт гэнэ. Төлөвлөгөөт зогсолтын нийт хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.
- 7.3.3 Картын сүлжээний үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар хэсэгчлэн болон бүрэн зогсох төлөвлөгөөт бус зогсолтыг гэнэтийн саатал гэнэ. Гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас хэтрэхгүй байна.
- 7.3.4 Клирингийн төв нь Гишүүн банкны төлөвлөгөөт зогсолт, гэнэтийн саатлын хугацааны тайланг долоо хоног бүрийн даваа гараг болон сар бүрийн 10-ны өдрийн дотор гаргаж Монголбанкны эрх бүхий албан тушаалтанд энэхүү дүрмийн Хавсралт 7-н дагуу мэдэвлэнэ.
- 7.3.5 Төлөвлөгөөт зогсолт, гэнэтийн саатал нь дараах шалтгаантай байх ба Гишүүн банк нь доор заасан шалтгааны кодыг ашиглана. Үүнд:

№	Шалтгааны код	Шалтгаан
1	01	Банкны суурь бүртгэлийн системээс
2	02	Картын программ хан

- 7.4.1.а. Төлөвлөгөөт зогсолт нь нэг удаад 30 минут хүртэл хугацаанд үргэлжлэх бөгөөд төлөвлөгөөт зогсолтыг 1-ээс доошгүй цагийн өмнө www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 7.4.1.б. Төлөвлөгөөт зогсолт 30 минутаас дээш хугацаатай үргэлжлэх бол 24 цагийн дотор www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан мэдэгдсэнээр шөнийн 01 цагаас 06 цагийн хооронд хийж гүйцэтгэнэ.
- 7.4.1.в. Төлөвлөгөөт зогсолтын нийт хугацаа сард 4 цагаас илүүгүй байна. Хэрэв 4 цагаас дээш хугацаанд төлөвлөгөөт зогсолт хийх бол үйл ажиллагааг нөөц төврүү шилжүүлж ажиллах ба операторт 24 цагийн өмнө www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 7.4.2 Энэхүү дүрмийн 7.4-т заасан шаардлагыг хангаагүй зогсолтыг гэнэтийн саатал гэж тооцно.
- 7.4.3 Гишүүн банк нь төлөвлөгөөт зогсолтын эхлэх огноо, цагийг өөрчлөх бол төлөвлөгөөт зогсолт эхлэхээс 3-аас 12 цагийн өмнө www.cardcentre.mn цахим хуудсаар илгээсэн саатлын хүсэлтийг дахин илгээнэ.
- 7.4.4 Гишүүн банк нь төлөвлөгөөт зогсолт дуусах цагийг биелэлтээр өөрчлөх бол тухай бүр www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 7.5 Гэнэтийн саатал
- 7.5.1 Гэнэтийн саатлын үед энэхүү дүрмийн 7.5.2 дахь заалтын дагуу Гишүүн банк нь ХХБ-нд, 7.5.3 дахь заалтын дагуу бусад талуудад нэн даруй мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авна.
- 7.5.2 Гишүүн банк нь төлбөрийн картын үйл ажиллагаанд гэнэтийн саатал гарсан тохиолдолд нэн даруй арга хэмжээ авч саатлын талаарх мэдэгдлийг доор дурдсан байдлаар тус бүрд нь ХХБ-нд ирүүлнэ. Үүнд:
- 7.5.2.а. Утсаар 10 минутын дотор;
- 7.5.2.б. ХХБ-ны cmd@tdbm.mn цахим хаягаар болон www.cardcentre.mn цахим хуудсаар 1 цагийн дотор дамжуулан ирүүлнэ.
- 7.5.3 Клирингийн төв нь төлбөрийн картын үйл ажиллагаанд гарсан аливаа гэнэтийн саатлын тухай бусад оролцогч талуудад мэдэгдэл хийхдээ доор дурдсан байдлаар хийнэ. Үүнд:
- 7.5.3.а. Утсаар 10 минутын дотор;
- 7.5.3.б. Гишүүн банканд 1 цагийн дотор www.cardcentre.mn цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 7.6 Гишүүн банк нь бусад оролцогчийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц системийн өөрчлөлтийг хийх тохиолдолд өөрчлөлт оруулахаас ажлын 15-аас доошгүй хоногийн ө

- журам”-д заасан шаардлагыг хангаж, Монголбанкнаас зөвшөөрөл авсан карт гаргагч, карт хүлээн авагчийг Клирингийн системийн гишүүнээр бүртгэнэ.
- 8.1.2 Гишүүн банк нь Клирингийн төвийн сүлжээний Гишүүнээр бүртгүүлэх зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг ХХБ-нд ирүүлнэ.
- 8.1.2.а. Банкны танилцуулга;
 - 8.1.2.б. Монголбанкнаас авсан зөвшөөрлийн хуулбар;
 - 8.1.2.в. Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 8.1.2.г. Байгууллагын зохион байгуулалтын бүтцийн дүрслэл;
 - 8.1.2.д. Картын үйлчилгээний бизнес төлөвлөгөө болон үзүүлэх төлбөрийн үйлчилгээний талаарх танилцуулга, холбогдох баримт бичиг;
 - 8.1.2.е. Техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл;
 - 8.1.2.ё. Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;
 - 8.1.2.ж. Бусад холбогдох бичиг, баримт.
- 8.1.3 Зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэхүү дүрмийн 8.1.2-д заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж ирүүлснээс хойш Клирингийн төв нь Гишүүн банкаар бүртгэх эсэх асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэж, шийдвэр гарснаас хойш хүсэлт гаргагчид гурав хоногийн дотор мэдэгдэнэ.
- 8.1.4 Энэхүү дүрмийн 8.1-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд Клирингийн төвийн сүлжээний Гишүүн банкаар бүртгэхийг ХХБ-ны Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 8.2 Клирингийн төвийн Гишүүн банкнаас түдгэлзүүлэх, хүчингүй болгох
- 8.2.1 Гишүүн банк дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг эрх бүхий байгууллагаас зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;
 - 8.2.2 Гишүүн банк зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь зөвшөөрөл авснаас хойш илэрсэн;
 - 8.2.3 Гишүүн банк Клирингийн төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулснаас хойш зургаан сараас дээш хугацаанд зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхэлж эхлээгүй.
- 8.3 БИН дугаар бүртгүүлэх
- 8.3.1 Клирингийн төв нь Гишүүн банкны БИН дугаарыг шинээр бүртгүүлэх, өөрчлөлт оруулахдаа БИН дугаар хүчинтэй болох хугацаанаас хуанлийн 10 хоногийн өмнө энэхүү дүрмийн Хавсралт 6-д заасан Маягтын дагуу ХХБ-ны cmd@tdbm.mn цахим хаягаар ирүүлнэ.
 - 8.3.2 Клирингийн төв нь Гишүүн банкны шинээр бүртгүүлсэн БИН дугаарыг ажлын гурван хоногийн дотор өөрийн системд хү

- ISO 7812-2

- ISO 7813

- 8.4.3 Клирингийн төв нь Гишүүн банктai зөвшилцсөний дагуу төлбөрийн картын гүйлгээний цахим мэдээг тухайн Гишүүн банкны цахим мэдээний бүтцэд тааруулж хөрвүүлэлт хийж өгч болно. Гишүүн банк нь Клирингийн төвтэй хөрвүүлэлтийг туршиж, баталгаажуулна.
- 8.5 Сүлжээний шаардлага
- 8.5.1 Гишүүн банк нь үндсэн болон нөөцийн төвтэй байх ба Гишүүн банкны үндсэн төвийг ХХБ-ны үндсэн төвтэй үндсэн болон нөөц шугамаар холбосон байх шаардлагатай. Мөн Гишүүн банкны нөөцийн төв нь ХХБ-ны нөөцийн төвтэй холбогдсон байх шаардлагатай. Эдгээр үндсэн төвтэй болон нөөцийн төвтэй холбогдож байгаа үндсэн болон нөөцийн шугам нь шилэн кабелийн холболт байна.
- 8.5.2 Гишүүн банк нь өөрийн сүлжээний нууцлалыг хангаж ажиллана.
- 8.5.3 Гишүүн банкны Клирингийн төвтэй холбогдсон үндсэн болон нөөц сүлжээний холболт нь хоорондоо автоматаар шилждэг байна.
- 8.5.4 Гишүүн банкны сүлжээний төхөөрөмж нь Клирингийн төвийн сүлжээний төхөөрөмжтэй нийцэж ажиллах боломжтой байна.
- 8.5.5 Гишүүн банк нь үндсэн болон туршилтын сүлжээний орчинг тусгаарласан байдлаар зохион байгуулна.
- 8.6 Туршилт, баталгаажуулалт хийх
- 8.6.1 Гишүүн банк нь Клирингийн төвийн Гишүүн банкаар элсэхээс өмнө болон шинэ үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд Клирингийн төвийн туршилтын төлөвлөгөөг баримталж, техник, програм хангамжийн туршилтыг Клирингийн төвтэй хамтран гүйцэтгэж, хоёр талаас баталгаажуулсан байна.
- 8.7 Гүйлгээний бүтцэд өөрчлөлт оруулах
- 8.7.1 Клирингийн төв нь шинэ үйлчилгээ, технологи нэвтрүүлэх зорилгоор гүйлгээний бүтцэд өөрчлөлт оруулах тохиолдолд үндсэн системд нэвтрүүлэхээс ажлын 45 хоногийн өмнө Оролцогч талуудад мэдэгдэнэ.
- 8.7.2 Клирингийн төв нь шинэчлэгдсэн мессежний бүтцэд тохирсон туршилтын төлөвлөгөөг боловсруулж, Оролцогч талуудад ажлын 30 хоногоос доошгүй хугацааны өмнө хүргүүлэх бөгөөд дээрх хугацаанд Гишүүн банк туршилтыг ХХБ-тай хамтран гүйцэтгэж, баталгаажуулсан байна.

Ес. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

9.1 Эрсдэлийн удирдлага

- 9.1.1 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 39.1-д заасны дагуу төлбөрийн найдвар

- 9.1.4 Гишүүн банкны олон улсын төлбөр тооцоог найдвартай, аюулгүй байдлыг хангах, үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор Гишүүн банк нь хамтран ажиллах гэрээний дагуу ХХБ-нд барьцаа хөрөнгийг байршуулна.
 - 9.1.5 Энэхүү дүрмийн 9.1.4-д заасан барьцаа хэлбэрээр барьсан хөрөнгийг “Хамтран ажиллах гэрээ”-г дуусгавар болгосноор чөлөөлнө.
 - 9.1.6 Энэхүү дүрмийн 9.1.4-д заасан ХХБ-нд байршиж буй барьцаа хөрөнгөтэй холбогдон үүсэх харилцааг Оролцогч талуудын хооронд байгуулсан “Барьцаа ба нөхөн төлбөрийн гэрээ”-ээр нарийвчлан зохицуулна.
- 9.2 Гишүүн банк төлбөрийн чадваргүй болох
- 9.2.1 Гишүүн банк дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг эрх бүхий байгууллагаас зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд Клирингийн төв нь “Хамтран ажиллах гэрээ” болон “Төлбөрийн картын төлбөр тооцоог гүйцэтгэх гэрээ”-ний дагуу шаардлагатай тохиолдолд Гишүүн банканд үзүүлж буй картын үйл ажиллагаа, үйлчилгээг зогсооно.
 - 9.2.2 Клирингийн төв нь Гишүүн банкны төлбөр тооцоог зогсоосон тухай мэдээллийг Бусад гишүүн банкууд болон дотоодын банкуудад яаралтай мэдэгдэнэ.
 - 9.2.3 Клирингийн төв нь Монголбанкаас Гишүүнийн төлбөр тооцоог түр зогсоох тухай мэдээллийг хүлээн авсан тохиолдолд тухайн Гишүүн банктай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - 9.2.3.а. Гүйлгээг нь дамжуулахгүй байх;
 - 9.2.3.б. Харилцах, хадгаламжийн болон бусад дансдын эрх нь хаагдахаас өмнөх төлбөрийг барагдуулах.

Арав. ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 10.1 Төлбөрийн картын гүйлгээг дамжуулахтай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах
- 10.1.1 Төлбөрийн системийн эрх зүйн орчны өөрчлөлт, техник, програм хангамжийн шинэчлэл зэрэг хүчин зүйлээс шалтгаалж дүрэмд нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд ХХБ-ны гүйцэтгэх захирлын тушаалаар тус нэмэлт, өөрчлөлтийг батална.
 - 10.1.2 Эрх зүйн орчны өөрчлөлтөөс шалтгаалж агуулгын бус зөвхөн дүрмийн нэр томьёо, үг хэллэгт өөрчлөлт орох нөхцөлд гишүүн банкнаас санал авахгүйгээр баталгаажуулж, дүрмийн нэмэлт өөрчлөлтийг ажлын 10 /арав/ хоногийн дотор